



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/318

Зуунмод

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх тухай

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн нэгдүгээр хурлын шийдвэртэй танилцаад Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.21 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагуудыг нэгдүгээр, түдгэлзүүлэх байгууллагуудын нэрсийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд хуулийн хугацаанд бичгээр мэдэгдэхийг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын Ажлын албанд даалгасугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, стандарт мөрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс /С.Мөнхтуяа/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2020 оны
05 дугаар сарын 27 -ны өдрийн
A/318 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	“Нутгийн арвай” ХХК	Нүүр амны үндсэн мэргэшлийн тусламж үйлчилгээ	3 жил
2	“Байгаль анар” ХХК	Хүүхдийн үндсэн мэргэшлийн тусламж үйлчилгээ	3 жил
3	“Гишүүгэнэ” ХХК	Эмийн сангийн чиглэлээр	3 жил
4	“Чандмань леди мед” ХХК	Эх барихын үндсэн мэргэшлийн тусламж үйлчилгээ	3 жил

___оОо___

Аймгийн Засаг даргын 2020 оны
05 дугаар сарын 27 -ны өдрийн
А/318 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хугацаа
1	“Болдшагаан” ХХК	Шүдний эмнэлэг	3 сар
2	“СОСУ” ХХК	Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйл ажиллагаа	3 сар